

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 12 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны есдүгээр сарын 28-ны өдрийн 14 цаг 5 минутад эхэлж, 15 цаг 25 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай.	Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Алтангэрэлийн Соёл-Эрдэнэ 82,74 оноогоор тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэн, тус албан тушаалд нэр дэвшүүлж, холбогдох материалын тухайн байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.
2	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх зараар бүртгүүлсэн иргэдийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй Цэрэндагвын Идэр-Оргилыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв
3	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Луус сумын Соёлын Төвийн эрхлэгч, Өлзийт Сайнцагаан, Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай.	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Луус сумын Соёлын Төвийн эрхлэгч, Өлзийт Сайнцагаан, Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 10 дугаар сарын 24-25 – ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэж материалыг ТАЗ-д хүргүүлэхээр болов.
4	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 10, туслах түшмэлийн 21 нийт 31 сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлахаар шийдвэрлэж, ТАЗ-д хүргүүлэхээр болов.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ